

# АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ 2018/002

2018 оны 11 дугаар сарын 29-ны өдөр

Нэг талаас “Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨТҮГ (цаашид “Захиалагч гэх”)-г төлөөлж дарга Чойжилсүрэн овогтой Элбэгсайхан, Нөгөө талаас “САТУ” ХХК (цаашид “Ажил гүйцэтгэгч гэх”)-г төлөөлж захирал Туваансүрэн нар байлцаж дараахь гэрээг харилцан тохиролцож байгуулав.

## 1. Нийтлэг заалт

- 1.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн даалгаврын дагуу дараахь ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:
  - 1.1.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7-р зүйлийн 7.3-т заасны дагуу БҮТП ОНӨТҮГ-н эзэмшлийн 414,0 га газарт байгаль орчны өнөөгийн төлөв байдлын үнэлгээг Байгаль орчин, Ногоон хөгжлийн сайдын /хуучин нэрээр/ 2014 оны А-117 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.
  - 1.1.2. Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын үнэлгээнд үндэслэн тайлан боловсруулан гаргана.
- 1.2. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын хөлсийг гэрээгээр тохиролцсон хэлбэр, хугацаанд төлнө.

## 2. Гэрээний хугацаа

- 2.1. Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарийн тооллыг удирдлага болгоно.
- 2.2. Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа: 24 хоног байна.
- 2.3. Ажил эхлэх хугацаа: 2018 оны 11 сарын 30 өдөр
- 2.4. Ажил дуусах хугацаа: 2019 оны 01 сарын 10 өдөр

## 3. Ажлын хөлс

- 3.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс: 9'800,000 /Есөн сая найман зуун мянган/ төгрөг байна.
- 3.2. Ажлын хөлсийг дараахь хэлбэр, хугацаагаар төлнө. Үүнд:
  - 3.2.1. ажил эхлэх урьдчилгаа: 2'995'474.00 төгрөг  
Ажлын гүйцэтгэл хүлээн авсны дараа: 6'804'500.00 төгрөг төлнө.

## 4. Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1. Ажил гүйцэтгэгч үүргээ биелүүлэхэд шаардагдах бичиг баримт болон бусад мэдээллийг өгнө.
- 4.2. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал ажил хүлээн авснаас хойш Нэг сарын дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

- 4.3. Гүйцэтгэсэн ажлын хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй.
- 4.4. Ажлын чанарын гүйцэтгэлд хяналт тавих, хартлцан зөвлөлдөх эрхтэй.

### **5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

- 5.1. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
- 5.2. Ажлыг биечлэн зураг болон стандартын дагуу гүйцэтгэнэ.
- 5.3. Ажил гүйцэтгэхээр захиалагчаас материалыг ажил дууссаны дараа захиалагчид буцаан өгнө.
- 5.4. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

### **6. Талуудын хүлээх хариуцлага**

- 6.1. Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,0 хувийн алданги төлнө.
- 6.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

### **7. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 7.2. Дээрхи давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

### **8. Бусад заалт**

- 8.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 8.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 8.3. Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Үндэсний Арбитрт түүний Арбитрын Хэрэг Шийдвэрлэх Дүрмийн дагуу Монгол Улсад Эцэслэн шийдвэрлүүлнэ.

### **9. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам**

- 9.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно

10. Нэмэлт нөхцөл

---

---

---

---

---

---

11. Талуудын хаяг

Захиалагч:

Гүйцэтгэгч:

Хаяг: БҮТП ОНӨТҮГ,  
Багануур 1-р хороо, Нацагдарж  
талбай, "МХС" ТӨХК-н байр,  
217 тоот

Хаяг: "САТУ" ХХК, РД:2110695  
Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,  
Барилгачдын талбай, "Барилга" ХК-  
ийн байр, 23 тоот

Утас: 70213292

